

**Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны
хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний
биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн
(2023 оны жилийн эцсийн байдлаар)**

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” тус тус батлагдсан.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт КОВИД-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлогын “КОВИД-19 халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийг хүндрэлийг даван туулах арга хэмжээг хэрэгжүүлэх” зорилтын хүрээнд 2023 онд Эрүүл мэндийн яам үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаар 10 арга хэмжээ; Хүний хөгжлийн бодлогын “Эрүүл мэнд, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах” зорилтын хүрээнд Эрүүл мэндийн яам үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаар 67 арга хэмжээ; Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтарсан 2 арга хэмжээ; Засаглалын бодлогын “Мэргэшсэн хариуцлагатай төрийн алба. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой цомхон болгох” зорилтын хүрээнд 1 арга хэмжээ; Ногоон хөгжлийн бодлогын “Ногоон хөгжил. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх” зорилтын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамт 1 арга хэмжээ, нийт 81 арга хэмжээ хэрэгжүүлэхээр байна.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт 2022 онд эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлэх арга хэмжээ хүлээгдэж буй үр дүндээ хүрч байгаа эсэхийг нягтлах, арга хэмжээ тус бүрийн хүрсэн түвшинг тодорхойлох, шаардлагатай санал, зөвлөмжийг боловсруулах, шийдвэр гаргагч нарт холбогдох мэдээлэл өгөх зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж гүйцэтгэсэн болно.

Хоёр. Хяналт-шинжилгээ үнэлгээний арга зүй

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэлгээг хийж, журмын дөрөвдүгээр хавсралт ёсоор тайланг нэгтгэн гаргасан. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийг журмын 6.2.2, 6.2.3 дугаар

заалтад заагдсан бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлэх аргачлалыг баримтлан арга хэмжээний хэрэгжилтийн хувиар тооцон гаргасан.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн байдлаар 64.4 хувьтай үнэлэгдсэн.

2023 онд төлөвлөгдсөн 81 арга хэмжээнээс 100 хувийн хэрэгжилттэй 35 (43.2%) арга хэмжээ, 90 хувийн хэрэгжилттэй 1 (1.2%) арга хэмжээ, 70-88.6 хувийн хэрэгжилттэй 14 (17.3%) арга хэмжээ, 50-60.6 хувийн хэрэгжилттэй 8 (9.9%) арга хэмжээ, 30-31.2 хувийн хэрэгжилттэй 6 (7.4%) арга хэмжээ, 11.7 хувийн хэрэгжилттэй 1 (1.2%) арга хэмжээ, 0 хувийн хэрэгжилттэй 16 (19.8%) арга хэмжээ тус тус байна.

“Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 50.0-60.6 хувийн хэрэгжилттэй 8 арга хэмжээ байна. Үүнд:

2.1.1.4. "Хавдрын эсрэг" арга хэмжээ хэрэгжүүлнэ (НЭМГ);

2.1.1.5. "Элэг бүтэн Монгол" арга хэмжээ хэрэгжүүлнэ (ЭТҮГ);

2.1.1.6. "Харшлаас сэргийлэх" арга хэмжээг хэрэгжүүлнэ (НЭМГ);

2.1.5.4. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийг боловсруулж батлуулна (НЭМГ);

2.1.6.5. Эрүүл мэндийн мэдээллийн үндэсний төв байгуулна (БТГ);

2.1.7.3. Урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар гаргаж, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаар гүйцэтгүүлэн, Улсын төсөв (ЭМД)-өөс санхүүжүүлнэ (БТГ);

2.1.13.1. Өрхийн эрүүл мэндийн төвийн эрхзүйн баримт бичигт шинэчлэл хийж, өрхийн эрүүл мэндийн төвийн хувилбаруудыг туршиж, оновчтой хэлбэрийг сонгон нэвтрүүлнэ (БТГ);

2.5.8.7. Гэр бүл, хүүхэд, залуучууд, ахмад настны хөгжлийн цогц төвүүдийг байгуулж, хүн амын бүлгүүдийн онцлогт нийцсэн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлнэ (НЭМГ).

“Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30-31.2 хувийн хэрэгжилттэй 6 арга хэмжээ байна. Үүнд:

2.1.4.1. Орон нутагт шаардлагатай газарт яаралтай тусламжийн цэг байгуулна (ЭТҮГ);

2.1.5.6. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна (БТГ);

2.1.7.1. Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сан байгуулна (БТГ);

2.1.7.6. Санхүүжилтийн гүйцэтгэл, удирдлагын хагас бие даасан байдалтай уялдуулан эрүүл мэндийн байгууллагуудын хөгжлийн төлөвлөлтийг хэрэгжүүлнэ (БТГ, ТЗУГ);

2.1.8.1. Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл, хяналтыг нэвтрүүлнэ (БТГ);

2.1.8.4. Нянгийн тэсвэржилтийн хяналтын дэлхийн сүлжээнд нэгдэж, нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээг хянах тогтолцоог бүрдүүлнэ (ЭТҮГ).

“Үр дүнгүй” буюу 11.7 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ байна. Үүнд:

2.1.7.2. Төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад Улсын төсөв (ЭМДС)-өөс амбулатори, өдрийн эмчилгээ, оношилгоонд олгох санхүүжилтийн ялгааг арилгана (СЭЗГ).

“Үр дүнгүй” буюу 0 хувийн хэрэгжилттэй 16 арга хэмжээ байна. Үүнд:

1.1.3.2. Шаардлагатай аймгуудад зоонозын өвчин судлалын төв, хил дагуух боомтод тандалтын нэгж байгуулна (НЭМГ, СЭЗГ);

1.1.3.5. Өвчний хяналт, сэргийлэлтийн төв байгуулна (БТГ);

2.1.2.2. Д вирустэй иргэдийг эмчилгээнд хамруулна (ЭТҮГ);

2.1.3.1. Эрхтэн шилжүүлэн суулгах төв байгуулна (СЭЗГ);

2.1.3.2. Зүрх судасны төв байгуулна (СЭЗГ);

2.1.3.3. Сүрьеэгийн эмнэлэг барьж, ашиглалтад оруулна (СЭЗГ);

2.1.3.6. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цогцолбор салбар II байгуулна (СЭЗГ);

2.1.3.7. Хавдар судлалын үндэсний төвийн салбар II байгуулна (СЭЗГ);

2.1.3.8. Баянзүрх дүүрэгт 300 ортой эмнэлэг барина (СЭЗГ);

2.1.5.7. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах лавлагаа төвийн чадавхыг нэмэгдүүлж, аймаг, дүүрэг Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулна (БТГ);

2.1.7.7. Эрүүл мэндийн үндэсний тооцоо болон тусламж, үйлчилгээний тариф тогтооход ашиглах зорилгоор тусламж, үйлчилгээний өртгийн бүртгэлийн цахим тогтолцоог эрүүл мэндийн байгууллагуудад нэвтрүүлнэ (БТГ);

2.1.7.11. Төрөөс хариуцах иргэдийн шимтгэл, албан бус салбарын даатгуулагчдын хамрагдалт, шимтгэлийн хэмжээг өсгөх замаар Улсын төсөв (ЭМДС)-гийн орлогыг нэмэгдүүлнэ (БТГ);

2.1.9.5. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлнэ (БТГ);

2.1.11.2. Ховд аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн барилгын өргөтгөл барина (СЭЗГ);

2.1.14.1. Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгоно (НЭМГ, СЭЗГ);

5.1.4.2. Аялал жуулчлалын бааз болон худалдаа, үйлчилгээний байгууллагуудын ариун цэврийн байгууламжийг стандартын шаардлага хангуулна (НЭМГ).

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний 10 шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин 2023 оны эхний 11 сарын байдлаар 29.4 хувь байна. Үүнээс зорилтот түвшиндээ хүрсэн буюу “Үр дүнтэй”, 100.0 хувийн үнэлгээтэй 2 шалгуур үзүүлэлт, “Эрчимжүүлэх шаардлагатай”, 55.0 хувийн үнэлгээтэй 1 шалгуур үзүүлэлт, “Үр

дүнгүй”, 13.5-26.0 хувийн үнэлгээтэй 2 арга хэмжээ, 0 хувийн үнэлгээтэй 5 шалгуур үзүүлэлт тус тус байна.

Дөрөв. Дүгнэлт

1. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эрүүл мэндийн салбарын 81 арга хэмжээний хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн байдлаар 64.4 хувийн үнэлгээтэй байна.

2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 14 арга хэмжээний хэрэгжилт 30 болон 50 хувь буюу “Эрчимжүүлэх шаардлагатай” гэсэн үнэлгээтэй байна.

3. “Үр дүнгүй” гэсэн үнэлгээтэй 17 арга хэмжээ байна.

4. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний 10 шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин 29.4 хувь байна.

5. Арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнахдаа зарцуулсан санхүүжилт, эх үүсвэрийг тайлагнаагүй байгааг цаашид анхаарах шаардлагатай.

Тав. Цаашид анхаарах асуудал, зөвлөмж

1. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эрүүл мэндийн салбарын арга хэмжээний төлөвлөгөөний 2023 оны жилийн эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр “Эрчимжүүлэх шаардлагатай” болон “Үр дүнгүй” байгаа арга хэмжээний хэрэгжилтийг 2024 онд эрчимжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах шаардлагатай байна.

2. Тайлагналтыг оновчтой, шалгуур үзүүлэлтийн дагуу, зарцуулсан санхүүжилт, эх үүсвэрийн хамт тодорхой тайлагнаж байхыг анхаарч ажиллах нь зүйтэй.

3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2024 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг хариуцан гүйцэтгэх газар, хэлтэс нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бүрэн тусгаж, Төрийн захиргааны удирдлагын газраас хяналт тавих шаардлагатай.

Эрүүл мэндийн яам
2023 оны 12 дүгээр сарын 25